

**Удирдах ажилтнуудын 09 дүгээр сарын 19-ний өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2022 оны 09 дүгээр сарын 26

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт
1.	Зохион байгуулах гэж буй үйл ажиллагаа, арга хэмжээний мэдээллээ видео хэлбэрээр бэлтгэн нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарах	Тухай бүр	Бүх байгууллага	<p>Зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг видео хэлбэрээр олон нийтэд дараах байгууллагууд хүргэсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Ус Ду ОНӨААТҮГазраас “Цэвэрлэх байгууламжийн шав тавих ёслол” –ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл -Насан туршийн боловсролын төвөөс “Боловсролтой боржигин малчин-2022” нөлөөллийн арга хэмжээний талаарх мэдээлэл Дараах байгууллагууд зохион байгуулах гэж байгаа болон зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг бэлтгэн өөрсдийн фейсбүүк группээр олон нийтэд хүргэсэн байна. Үүнд: -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас “Ажил хийх гоё” өдөрлөгийн хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээлэл -Улсын бүртгэлийн газраас “Иргэний тоон гарын үсэг олгох” мэдээлэл -Боловсрол, шинжлэх ухааны газраас “Боловсролын салбарт ажиллаж байсан ахмад багш, ажилтнуудын өдөрлөг” арга хэмжээний талаарх мэдээлэл -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас “Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах талаарх мэдээлэл -Сум дундын ойн анги “Мод бут тарих, услах, арчлах” талаарх зөвлөмж мэдээлэл
2.	Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж зардал төсвийг бодитой тооцоолж гаргах, хүлээн авалт хийхгүй байх, бусад хэмнэх болох зардлуудыг хэмнэх	Тухай бүр	Бүх байгууллага	<p>Байгууллагууд Төсвийн хэмнэлтийн тухай хууль, түүний биелэлтийг хангахаар тодорхой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй байна.</p> <p>Мөн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, тулгамдаж буй асуудал, саналыг хүргүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Аймгийн төрийн байгууллагууд Төсвийн төсөл болон 2022 оны төсвийг хуваарилахдаа хэмнэлтийн хуулийг үндэслэн төлөвлөөгүй учир төсвийн тодотголоор зарим зардлыг хасаж багасгасан нь хэмнэгдэх боломж багатай, аж ахуй нэгж, иргэд рүү чиглэсэн үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй, бусад хууль, журамтай зөрчилдөж байгаа, орон нутгийн өмчид бүртгэлтэй автотээврийн талаарх асуудал, автомашины дуудлага үйлчилгээ, үйлчилгээний үнэ тариф, автомашины тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар суудлын автомашины км-ын хэмжилт зэргийг тусгасан журам батлагдаагүй тул хэрэгжилтийг ханган ажиллахад хүндрэлтэй байгаа талаар саналыг хүргүүлсэн байна. Санхүү, төрийн сангийн хэлтэсд сарын мэдээний хамтаар Төсвийн тухай хуулийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг ирүүлэх чиглэлийн дагуу дараах байгууллагууд тайланг ирүүлсэн байна. Үүнд: Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Боржигин чуулга, Илчлэг Шивээ ОНӨҮГазар

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС